

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/20

Өлгий

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэндийн газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай.

Дарга: Ш.Иманхан – хяналт,шинжилгээ,үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Х.Наурызбек - хуулийн эрх зүй, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, өргөдөл хариуцсан ажилтан

С.Бекет – эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ хариуцсан ажилтан

Т.Ердаулет – дархлаажуулалтын асуудал хариуцсан ажилтан

М.Халайх - мэдээлэл технологи, телемедицин, зайн анагаах ухаан хариуцсан ажилтан

2.Байгууллагын үндсэн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт болон зайлшгүй шаардлагатай эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах, дахин үнэлэх асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэж ажиллахыг Өмч хамгаалах зөвлөлд даалгасугай.

3.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллан, үр дүнг танилцуулж байхыг Өмч хамгаалах зөвлөл /Ш.Иманхан/-д үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/20 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Н.САКЕН